



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 12 сарын 01 өдөр

Дугаар 9/04

Эрдэнэт

Газрын харилцааны талаар
2018 онд баримтлах үйл ажиллагааны
чиглэл батлах тухай

Монгол Улсын “Газрын тухай хууль”-ийн 20 дугаар зүйлийн 20.1.2, “Хот байгуулалтын тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.1.3, “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”-ийн 11 дүгээр зүйлийн 11.1.2-т заасныг үндэслэн аймгийн хэмжээнд Газрын харилцааны талаар 2017 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлангийн тухай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Д.Цолмонгийн илтгэлийг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Газрын харилцааны талаар 2018 онд баримтлах үйл ажиллагааны чиглэлийг нэгдүгээр, аж ахуйн зориулалтаар иргэн, аж ахуйн нэгжид шинээр эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээг хоёрдугаар, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй өмчлүүлэх газрын байршил, хэмжээг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Тогтоолын биелэлтийн явцыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд хагас жилээр, аймгийн ИТХ-ын хуралдаанд бүтэн жилээр тайлагнахыг аймгийн Засаг дарга /Д.Батлут/-д даалгасугай.

ДАРГА  П.ПҮРЭВЛХАГВА



C:\Togtool \-A4 doc

00100191